

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар  
сарын ... - ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Олон улсын гэрээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Улаанбаатар хотноо 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр гарын үсэг зурсан “Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг баталсугай.

ГАРЫН ҮСЭГ

## ТАНИЛЦУУЛГА

“Агаарын тээврийн тухай Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн тухай

Засгийн газраас “2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамнаас агаарын харилцааг өргөжүүлэх, нислэгийн чиглэл, давтамжийг богино хугацаанд эрчимтэй нэмэгдүүлэх зорилт тавьж, 2023-2024 онд нэмж 10 орчим улстай агаарын харилцааны хэлэлцээр байгуулахаар төлөвлөсөн.

Энэ хүрээнд Америкийн Нэгдсэн Улстай агаарын харилцааны хэлэлцээр байгуулах ажлыг эрчимжүүлж, хэлэлцээрийн төслийг Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн. Улмаар Ерөнхий сайдын 2022 оны 223 дугаар захирамжаар “Агаарын тээврийн тухай Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурах эрхийг Зам, тээврийн хөгжлийн сайдад олгосон.


Монгол Улсын Ерөнхий сайдын АНУ-д хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд “Агаарын тээврийн тухай Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт Вашингтон хотноо 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдөр гарын үсэг зурсан болно.

“Агаарын тээврийн тухай Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг ийнхүү байгуулж, хоёр улсын хооронд шууд нислэг үйлдэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлснээр манай улсын иргэд АНУ руу хямд зардлаар тав тухтай зорчих, олон улс руу гарч буй мөнгөн урсгалыг дотооддоо авч үлдэх, үндэсний агаарын тээвэрлэгчдийн өрсөлдөх чадвар нэмэгдэж, агаарын харилцаа, нислэгийн сүлжээ өргөжин хөгжих боломж нээгдэж байна.

“Агаарын тээврийн тухай Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” нь нийт 18 зүйлтэй бөгөөд олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны Чикагогийн конвенцод нийцүүлэн, хоёр орны нутаг дэвсгэрийн хооронд болон хилийн чанадад агаарын харилцаа тогтоох зохицуулалтыг тохирсон, олон улсын нийтлэг жишгээр байгуулсан, агаарын харилцааны чөлөөтэй харилцааг зохицуулсан хэлэлцээр юм. Хэлэлцээрт нисэхийн аюулгүй ажиллагаа, нисэхийн аюулгүй байдлын тухай болон үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, тариф, гаалийн татвар, бусад хураамжийн тухай зохицуулалт, коммерийн боломж, шударга өрсөлдөөний зарчмыг тусгасан.

Энэхүү хэлэлцээр нь талууд тус тусын дотоодын журмаа гүйцээж, дипломат шугамаар харилцан мэдэгдсэнээр хүчин төгөлдөр болох тул Олон улсын гэрээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “... эрх олгогдсон албан тушаалтан олон улсын гэрээнд гарын үсэг зурсны дараа хоёр болон олон талт олон улсын гэрээг соёрхон батлах, эсхүл батлах саналыг тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөл, эсхүл батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийн хамт энэ хуулийн 9, 10 дугаар зүйлд заасан журмын дагуу Улсын Их Хурал, Засгийн газраар хэлэлцүүлнэ” гэж заасны дагуу “Хэлэлцээр батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан болно.

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**



**АГААРЫН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ**  
**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**  
**БОЛОН**

**ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**  
**ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар /цаашид Монгол Улс гэх/ болон Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Засгийн газар /цаашид Их Британи Улс гэх/, хамтад нь Хэлэлцэн тохиролцогч Талууд гэх;

Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс гарын үсэг зурахад нээлттэй болсон Олон Улсын Иргэний нисэхийн тухай Конвенцод оролцогч Хэлэлцэн тохиролцогч Талууд болохын хувьд;

Тус тусын нутаг дэвсгэрийн хооронд болон тэдгээрийн хилийн чанадад агаарын харилцаа тогтоох зорилгоор дээрх Конвенцын нэмэлт хэсэг болох хэлэлцээр байгуулахыг эрмэлзэн;

Дараах зүйлсийг тохиров:

**1 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

**Тодорхойлолт**

Энэхүү хэлэлцээрийн зорилгод нийцүүлэн, агуулгын хувьд өөрөөр заагаагүй бол:

- (а) "Нисэхийн удирдах байгууллага" гэж Монгол Улсын хувьд Зам, тээврийн хөгжлийн яам эсхүл Иргэний нисэхийн ерөнхий газар эсхүл аль ч тохиолдолд дээр дурдсан эрх бүхий байгууллагууд эсхүл адилхан чиг үүргийг гүйцэтгэхээр томилогдсон аливаа хүн эсхүл байгууллага, болон Их Британи Улсын хувьд Тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга эсхүл тус улсын Иргэний нисэхийн ерөнхий газар эсхүл хоёулаа, эсхүл тухайн нөхцөлд олон улсын харилцааг Их Британи Улсаас хариуцаж буй нутаг дэвсгэрийн адилтгах эрх бүхий байгууллага; мөн энэхүү

Хэлэлцээрийн 9 дүгээр зүйл (Үнэ тариф)-ийн хувьд тус улсын Иргэний нисэхийн ерөнхий газрыг хэлнэ;

- (b) "энэхүү Хэлэлцээр" гэж энэхүү Хэлэлцээр, түүний Хавсралт, тэдгээрт оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хэлнэ;
- (c) "Тохиролцсон үйлчилгээ" болон "тогтоосон маршрут" гэж энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар зүйл (2) дахь заалтад (Эрх олгох) заасан утгыг илэрхийлнэ;
- (d) "Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ" гэж тухайн агаарын тээвэрлэгч нь мэргэжлийн ур чадвартай болон гэрчилгээнд заасан нисэхийн үйл ажиллагааг явуулах агаарын хөлгийн аюулгүй ажиллагааг хангасан зохион байгуулалттай болохыг баталгаажуулан олгосон баримт бичгийг хэлнэ;
- (e) "Олон улсын агаарын тээврийн үйлчилгээ", "агаарын тээвэрлэгч" болон "арилжааны бус зорилготой буулт" гэсэн нэр томъёонууд нь Чикагогийн Конвенцын 96 дугаар зүйлд заасан утгыг илэрхийлнэ;
- (f) "Томилогдсон агаарын тээвэрлэгч" гэж энэхүү Хэлэлцээрийн 4 дүгээр зүйл (Томилгоо, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл)-ийн дагуу томилсон агаарын тээвэрлэгчийг хэлнэ;
- (g) "Чикагогийн Конвенц" гэж 1944 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Чикаго хотноо байгуулсан Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенц бөгөөд үүнд: (i) Хэлэлцэн тохиролцогч хоёр Талуудын соёрхон баталсан аливаа нэмэлт өөрчлөлт; болон (ii) энэхүү Конвенцын 90 дүгээр зүйлийн дагуу батлагдсан, аливаа Хавсралт эсхүл түүнд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хэлэх бөгөөд тухайн Хавсралт эсхүл нэмэлт өөрчлөлт нь Хэлэлцэн тохиролцогч Талуудын хувьд ямар ч үед хүчин төгөлдөр байна;
- (h) "ОУИНБ" гэх Олон улсын иргэний нисэхийн байгууллагыг хэлнэ;
- (i) "Үнэ тариф" гэж зорчигч, ачаа болон тээш тээвэрлэхэд төлөх үнэ тариф болон тэдгээр үнэ тариф үйлчлэх нөхцөлүүд бөгөөд үүнд агентлагийн болон бусад туслах үйлчилгээний үнэ, нөхцөлийг багтаах боловч шуудан тээвэрлэлтийн нөхөн олговор болон шуудан тээвэрлэлтийн нөхцөлийг хамааруулахгүй;
- (j) "Слот" гэж агаарын тээвэрлэгч буух эсхүл хөөрөх зорилгоор тодорхой өдөр, цагт нисэх онгоцны буудалд агаарын тээврийн үйлчилгээ явуулахад шаардлагатай дэд бүтцийг бүрэн ашиглах зөвшөөрөл олгосныг хэлнэ;
- (k) "Нутаг дэвсгэр" гэж Улсын хувьд Чикагогийн Конвенцын 2 дугаар зүйлд заасан утгыг илэрхийлнэ;
- (l) "Ашиглалтын хураамж" гэж нисэх буудал, түүний тоног төхөөрөмж эсхүл агаарын навигацийн тоног төхөөрөмж (өнгөрөлтийн нислэгт зориулсан тоног төхөөрөмж хамаарна), эсхүл агаарын хөлөг, түүний нисгэх баг, зорчигчид, ачаа тээшинд хамаарах тоног төхөөрөмж болон холбогдох үйлчилгээ үзүүлсний төлөө хураамж авах эрх бүхий байгууллагаас агаарын тээвэрлэгчид ногдуулж буй эсхүл ногдуулахыг зөвшөөрсөн хураамжуудыг хэлнэ.

## 2 ДУГААР ЗҮЙЛ

### Чикагогийн Конвенцыг хэрэглэх

Энэхүү Хэлэлцээрийн заалтууд нь Чикагогийн Конвенцын заалтуудын дагуу даган мөрдөгдөх бөгөөд эдгээр заалтууд олон улсын агаарын тээврийн үйлчилгээнд хамаарна.

## 3 ДУГААР ЗҮЙЛ

### Эрх олгох

1. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа олон улсын агаарын тээврийн үйлчилгээний дараах эрхийг олгоно:
  - (a) нутаг дэвсгэрт нь буулгүйгээр шууд дамжин нисэж өнгөрөх;
  - (b) нутаг дэвсгэрт нь арилжааны бус зорилготой буулт хийх.
2. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа Хэлэлцээрийн Хавсралтад орсон Хуваариар тогтоосон маршрутад олон улсын агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх эрх олгоно. Эдгээр үйлчилгээ болон маршрутыг цаашид "тохиролцсон үйлчилгээ" болон "тогтоосон маршрут" гэж нэрлэнэ. Тогтоосон маршрутад тохиролцсон үйлчилгээ үзүүлэхдээ Хэлэлцэн тохиролцогч Тал бүрээс томилогдсон агаарын тээвэрлэгч энэ зүйлийн (1) дэх заалтад заасан эрхүүдээс гадна олон улсын зорчигч, ачаа тээш, шууданг дангаар эсхүл хамтад нь агаарын хөлгийн бүхээгт авах, буулгах зорилгоор энэхүү Хэлэлцээрийн Хавсралт дахь тухайн маршрутын Хуваарьт заасан цэгүүдэд зогсолт хийх эрхтэй.
3. Энэ зүйлийн (2) дахь заалт нь Хэлэлцэн тохиролцогч нэг Талын томилсон агаарын тээвэрлэгч Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зорчигч, ачаа тээш, шууданг хөлсөөр эсхүл урамшууллаар тохирсон нэг цэгээс нөгөө цэг рүү тээвэрлэх эрх олгосон гэж ойлгохгүй.
4. Зэвсэгт мөргөлдөөн, улс төрийн асуудал, эсхүл онцгой буюу ердийн бус нөхцөл байдлын улмаас Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын томилсон агаарын тээвэрлэгч тухайн үйлчилгээг тогтоосон маршрутаар гүйцэтгэж чадахгүйд хүрвэл Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал тухайн үйл ажиллагааг нэн даруй үргэлжлүүлэхийн тулд маршрутын түр зуурын зохих зохицуулалт хийх талаар хүчин чармайлт гаргана.

## 4 ДҮГЭЭР ЗҮЙЛ

### Томилгоо, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

1. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр тогтоосон маршрут тус бүрт тохиролцсон үйлчилгээ үзүүлэх зорилгоор агаарын тээвэрлэгчдийг томилох болон эдгээр томилгоог буцаан татах эсхүл өөрчлөх эрхтэй. Ийм томилгоог Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа бичгээр уламжилна.

2. Ийм томилгоо болон томилогдсон агаарын тээвэрлэгчийн өргөдлийг үйлчилгээ үзүүлэх эрх, техникийн зөвшөөрөлд заасан загвар, байдлаар хүлээн авсны дараа Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал нь зохих зөвшөөрөл болон эрхийг удаашралгүй байдлаар дараах тохиолдолд олгоно:

a) Монгол Улсын томилсон агаарын тээвэрлэгчийн хувьд:

- i. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгуулагдсан бөгөөд Монгол Улсын холбогдох хуулийн дагуу гэрчилгээжсэн; болон
- ii. Монгол Улс нь агаарын тээвэрлэгчид үр нөлөөтэй зохицуулах хяналт тавьдаг, түүнийг хэрэгжүүлдэг; болон
- iii. Монгол Улс болон/эсхүл Монгол Улсын иргэд нь агаарын тээвэрлэгчийг шууд эсхүл олонхын өмчлөлөөр өмчилдөг, үр дүнтэй хяналт тавьдаг;

b) Их Британи Улсын томилсон агаарын тээвэрлэгчийн хувьд:

- i. Их Британи Улсын нутаг дэвсгэрт үүсгэн байгуулагдсан бөгөөд тус улсад бизнесийн үндсэн газартай; болон
- ii. Их Британи Улсын нисэхийн удирдах байгууллагаас олгосон одоогийн Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээтэй бөгөөд тухайн байгууллага нь агаарын тээвэрлэгчид үр нөлөөтэй зохицуулах хяналт тавьдаг, түүнийг хэрэгжүүлдэг;

болон

c) Өргөдөл эсхүл өргөдлүүдийг харгалзан олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаанд Хэлэлцэн тохиролцогч Талаас ердийн мөрддөг хууль болон дүрмийн дагуу тухайн томилсон агаарын тээвэрлэгч нь тогтоосон нөхцлийг хангах чадвартай байх.

3. Агаарын тээвэрлэгч нь энэхүү Хэлэлцээрийн мөрдөж болохуйц заалтуудыг хангасан нөхцөлд тухайн агаарын тээвэрлэгч эрхлэхээр томилогдсон тэр тохиролцсон үйлчилгээг эрхэлж болно.

## 5 ДУГААР ЗҮЙЛ

### Үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг цуцлах эсхүл түдгэлзүүлэх

1. Хэлэлцэн тохиролцогч аль ч Тал Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын агаарын тээвэрлэгчийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл эсхүл техникийн зөвшөөрлийг цуцалж, түдгэлзүүлж, хязгаарлаж болно:

a) Монгол Улсын томилсон агаарын тээвэрлэгчийн хувьд:

- i. Монгол Улсын нутаг дэвсгэрт үүсгэн байгуулагдаагүй эсхүл Монгол Улсын холбогдох хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах хүчин төгөлдөр гэрчилгээ байхгүй; эсхүл
- ii. Монгол Улс нь агаарын тээвэрлэгчид үр нөлөөтэй зохицуулах хяналт тавьдаггүй эсхүл түүнийг хэрэгжүүлдэггүй; эсхүл

- iii. Монгол Улс болон/эсхүл Монгол Улсын иргэд нь агаарын тээвэрлэгчийг шууд эсхүл олонхын өмчлөлөөр өмчилдөггүй эсхүл үр дүнтэй хяналт тавьдаггүй;
  - b) Их Британи Улсын томилсон агаарын тээвэрлэгчийн хувьд:
    - i. Их Британи Улсын нутаг дэвсгэрт үүсгэн байгуулагдаагүй эсхүл бизнес эрхлэх үндсэн газар байхгүй; эсхүл
    - ii. Их Британи Улсын нисэхийн удирдах байгууллагаас олгосон одоогийн Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшээгүй эсхүл тухайн эрх бүхий байгууллага нь агаарын тээвэрлэгчид үр нөлөөтэй зохицуулах хяналт тавьдаггүй эсхүл түүнийг хэрэгжүүлдэггүй; эсхүл
  - c) Агаарын тээвэрлэгч нь энэхүү Хэлэлцээрийн 6 дугаар зүйл (Хууль, дүрмийг дагаж мөрдөх)-д заасан хууль эсхүл дүрмийг, эсхүл эдгээр эрхийг олгосон Хэлэлцэн тохиролцогч Тал олон улсын агаарын тээврийн үйлчилгээ явуулахдаа ердийн болон үндэслэлтэй хэрэгжүүлдэг хуулийг дагаж мөрдөөгүй тохиолдолд; эсхүл
  - d) Агаарын тээвэрлэгч нь энэхүү Хэлэлцээрийн 7 дугаар зүйл (Шударга өрсөлдөөн)-д заасан заалтыг дагаж мөрдөөгүй (мөн энэ зүйлийн (9) дэх заалтын дагуу зөвлөлдөх уулзалтаар хангалттай шийдэлд хүрээгүй); эсхүл
  - e) Энэхүү Хэлэлцээрийн 11 дүгээр зүйлийн (14) дэх заалт (Нисэхийн аюулгүй байдал)-ын дагуу; эсхүл
  - f) Агаарын тээвэрлэгч эсхүл Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал нь энэхүү Хэлэлцээрийн 11 дүгээр зүйл (Нисэхийн аюулгүй байдал)-ийн аль нэг заалтыг биелүүлээгүй тохиолдолд; эсхүл
  - g) Хэлэлцэн тохиролцогч Талаас аюулгүй байдлын өргөн хүрээний асуудлыг тус үйлдлээр зөвтгөж байна гэж үзвэл; эсхүл
  - h) Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал энэхүү Хэлэлцээрийн 12 дугаар зүйл (Аюулгүй ажиллагаа)-ийн (2) дахь заалтын дагуу аюулгүй ажиллагааг сайжруулах талаар зохих арга хэмжээ аваагүй тохиолдолд; эсхүл
  - i) Энэхүү Хэлэлцээрийн 12 дугаар зүйл (Аюулгүй ажиллагаа)-ийн (6) дахь заалтад заасны дагуу; эсхүл
  - j) Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархахаас хамгаалах, хянах, эсхүл нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор холбогдох арга хэмжээ авах шаардлагатай тохиолдолд; эсхүл
  - k) Агаарын тээвэрлэгч энэхүү Хэлэлцээрт заасан нөхцөлийн дагуу үйл ажиллагаа явуулахгүй тохиолдолд.
2. Энэ зүйлийн (1) дэх заалтад заасны дагуу үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг нэн даруй хүчингүй болгох, цуцлах, түдгэлзүүлэх нь хууль тогтоомж, дүрэм журмыг цаашид зөрчихөөс урьдчилан сэргийлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үзсэнээс

бусад тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талтай урьдчилан зөвшилцсөний дараа хэрэгжүүлнэ.

3. Энэ зүйлийн (1) дэх заалтад заасан эрхээ эдэлж байгаа Хэлэлцэн тохиролцогч Тал нь үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хүчингүй болгох, техникийн зөвшөөрлийг түдгэлзүүлсэн эсхүл хязгаарласан шалтгааны талаар Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа бичгээр аль болох түргэн мэдэгдэнэ.
4. Хэлэлцэн тохиролцогч Талууд энэ зүйлийн (1) дэх заалтад заасан эрхээ хэрэгжүүлэхдээ агаарын тээвэрлэгчийн улсын харьяаллаар нь ялгаварлан гадуурхахгүй.

## 6 ДУГААР ЗҮЙЛ

### Хууль, дүрмийг дагаж мөрдөх

1. Олон улсын агаарын тээврийн үйлчилгээ эрхэлдэг агаарын хөлөг нь Хэлэлцэн тохиролцогч нэг Талын нутаг дэвсгэрт нэвтрэх, нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах, нутаг дэвсгэрээс нь нисэн гаргахтай холбоотой хууль тогтоомж, дүрэм журмыг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын агаарын тээвэрлэгчид дагаж мөрдөнө.
2. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын нутаг дэвсгэрт нэвтрэх, нутаг дэвсгэр дотор, эсхүл гарах үед агаарын хөлгөөр тухайн нутаг дэвсгэрт нэвтрэх болон гарч буй зорчигч, багийн гишүүд, ачаа, тээш болон/эсхүл шууданг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг (үүнд нэвтрэх, бүрдүүлэлт, цагаачлал, паспорт, гааль, хорио цээрийн журам, эсхүл шуудангийн хувьд холбогдох зохицуулалт) эдгээр зорчигч, багийн гишүүд, ачаа тээш, шууданг тээвэрлэгч нар эсхүл тэдгээрийн нэрийн өмнөөс Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал дагаж мөрдөнө.

## 7 ДУГААР ЗҮЙЛ

### Шударга өрсөлдөөн

1. Тогтоосон маршрутад тохиролцсон үйлчилгээ явуулахад Хэлэлцэн тохиролцогч хоёр Талын томилогдсон агаарын тээвэрлэгчдийг шударга, эрх тэгш боломжоор хангана.
2. Томилогдсон агаарын тээвэрлэгч нь тогтоосон маршрутад тохиролцсон үйлчилгээ явуулахдаа олон улсын агаарын тээврийн давтамж болон багтаамжийг өөрсдөө тодорхойлохыг Хэлэлцэн тохиролцогч Тал бүр зөвшөөрнө. Энэхүү эрхтэй нийцүүлэн Чикагогийн Конвенцын 15 дугаар зүйлд нийцсэн нөхцөлийн дагуу гааль, техник, ашиглалтын үйл ажиллагаа, эсхүл байгаль орчинтой холбоотой шалтгаанаас бусад тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль нь ч Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын томилогдсон агаарын тээвэрлэгчийн тээвэрлэлтийн хэмжээ, үйлчилгээний давтамж эсхүл тогтмол байдал, агаарын хөлгийн төрлийг дангаар хязгаарлахгүй.
3. Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль нь ч Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын томилогдсон агаарын тээвэрлэгчийн багтаамж, давтамж, эсхүл тээвэрлэлттэй холбоотойгоор шууд-татгалзах, ямарваа хураамж болон бусад аливаа шаардлагыг тавихгүй бөгөөд энэхүү Хэлэлцээрийн зорилгод нийцэхгүй юм.



4. Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль нь ч энэ зүйлийн (2) дахь заалтад заасан нөхцөлийг ялгаварлан гадуурхахгүйн үндсэн дээр хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын агаарын тээвэрлэгчийг нислэгийн хуваарь эсхүл үйл ажиллагааны төлөвлөгөөгөө өгөхийг шаардахгүй.
5. Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль нь ч өөрийн томилогдсон агаарын тээвэрлэгч эсхүл тээвэрлэгчдээ бусад агаарын тээвэрлэгч эсхүл тээвэрлэгчидтэй хамтран, эсхүл тус тусдаа зах зээлийн эрх мэдлээ урвуулан ашиглаж өрсөлдөгчөө сулруулах эсхүл өрсөлдөгчөө маршрутаас шахан гаргахыг зөвшөөрөхгүй.
6. Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль нь ч Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын агаарын тээвэрлэгч олон улсын агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх шударга өрсөлдөөн, тэгш боломжид сөргөөр нөлөөлөх байдлаар өөрийн томилогдсон агаарын тээвэрлэгч эсхүл тээвэрлэгчид төрөөс дэмжлэг эсхүл олговор авахыг зөвшөөрөхгүй.
7. Төрийн дэмжлэг эсхүл олговор гэдэг нь тусгайлсан агаарын тээвэрлэгчид төрөөс шууд болон шууд бусаар, эсхүл төрөөс томилсон, төрийн хяналтад байдаг төрийн болон хувийн байгууллагаас ялгаварлан гадуурхах үндсэн дээр дэмжлэг үзүүлэхийг хэлнэ. Ямар нэгэн хязгаарлалтгүйгээр эдгээр нь үйл ажиллагааны алдагдлыг тооцохгүй байх; мөнгөн дэмжлэг, буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох; ашиг дээр санхүүгийн давуу эрх олгох эсхүл өр төлбөрийг нөхөх; ашигласан төсвийн хөрөнгийг буцаан авахаас татгалзах; татвараас чөлөөлөх; төрийн эрх бүхий байгууллагаас ногдуулсан санхүүгийн дарамтаас чөлөөлөх; эсхүл агаарын тээврийн хэвийн үйл ажиллагаанд шаардлагатай нисэх онгоцны буудал, түлш болон бусад холбогдох байгууламжид ялгаварлалтай нэвтрүүлэх зэрэг болно.
8. Энэхүү Хэлэлцээрийн дагуу үйлчилгээ үзүүлж байгаа томилогдсон агаарын тээвэрлэгч Хэлэлцэн тохиролцогч Талын төрийн дэмжлэг эсхүл олговор авч байгаа тохиолдолд тухайн агаарын тээвэрлэгч нь энэхүү дэмжлэг эсхүл олговрын талаар дансандаа тодорхой болон тусад нь тодорхойлохыг шаардана.
9. Хэлэлцэн тохиролцогч нэг Тал өөрийн томилогдсон агаарын тээвэрлэгчийг ялгаварлан гадуурхалт, шударга бус үйлдэлд өртөж байна гэж үзвэл, эсхүл Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал нь тухайн Хэлэлцэн тохиролцогч Талын агаарын тээвэрлэгчдэд дэмжлэг эсхүл олговор олгосноор эхний Талд сөргөөр нөлөөлж байна гэж үзвэл, эсхүл Хэлэлцэн тохиролцогч эхний Талын агаарын тээвэрлэгчид олон улсын агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх шударга, тэгш боломжид нь сөргөөр нөлөөлж байгаа гэж үзвэл зөвлөлдөх уулзалт хийх хүсэлт гаргаж, зөвлөлдөх хүсэлтээ Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа мэдэгдэж болно. Хэлэлцэн тохиролцогч Талууд өөрөөр тохиролцоогүй бол энэхүү зөвлөлдөх уулзалт хийх хүсэлт хүлээн авснаас хойш 30-аас доошгүй хоногийн дотор зохион байгуулна.

## 8 ДУГААР ЗҮЙЛ

### Хөөрөлт болон буултын слот

Хэлэлцэн тохиролцогч Тал бүр өөрийн нутаг дэвсгэр дээрх нисэх буудлуудын слот хуваарилах зохицуулалт, заавар, дүрэм журмуудыг ил тод, үр дүнтэй, ялгаварлан гадуурхахгүй, цаг алдалгүй хэрэгжүүлнэ.

## 9 ДҮГЭЭР ЗҮЙЛ

### Үнэ

1. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр шударга өрсөлдөөний үндсэн дээр томилогдсон агаарын тээвэрлэгч бүр агаарын тээврийн үнийг чөлөөтэй тогтоохыг зөвшөөрнө. Хэлэлцэн тохиролцогч аль ч Тал энэхүү Хэлэлцээрийн дагуу тогтоохоор төлөвлөж байгаа болон ашиглаж буй үнийн талаар өөрийн агаарын тээвэрлэгчдийг бусад агаарын тээвэрлэгчидтэй зөвлөлдөхийг шаардахгүй.
2. Хэлэлцэн тохиролцогч Талууд үнийн мэдээллийг нисэхийн удирдах байгууллагуудад мэдэгдэхийг шаардахгүй.

## 10 ДУГААР ЗҮЙЛ

### Гааль, татвар, төлбөр

1. Хэлэлцэн тохиролцогч Талууд бүх гаалийн татвар, и дотоодын онцгой албан татвар болон түүнтэй адилтгах дотоодын хураамжаас дараахь зүйлийг чөлөөлнө.
  - a. Хэлэлцэн тохиролцогч аль ч Талаас томилогдсон агаарын тээвэрлэгч эсхүл тээвэрлэгчдийн олон улсын нислэг үйлдэж буй агаарын хөлөг;
  - b. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын томилогдсон агаарын тээвэрлэгч Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оруулсан дараах зүйлсийг:
    - (i) засвар, засвар үйлчилгээ, засвар үйлчилгээ хийх тоног төхөөрөмж, эд анги;
    - (ii) зорчигч тээврийн хэрэгсэл, эд анги;
    - (iii) ачаа ачих төхөөрөмж, эд анги;
    - (iv) хамгаалалтын төхөөрөмжид оруулах бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаасан хамгаалалтын тоног төхөөрөмж;
    - (v) сургалтын материал, сургалтын хэрэглэгдэхүүн;
    - (vi) агаарын тээврийн болон операторын баримт бичиг; болон
  - c. Хэлэлцэн тохиролцогч нэг Талаас томилогдсон агаарын тээвэрлэгч Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтрүүлсэн, эсхүл Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохиролцогч нэг Талын томилогдсон агаарын тээвэрлэгчид нийлүүлсэн дараах зүйлсийг:
    - (i) Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтрүүлсэн эсхүл агаарын хөлөгт авч явсан агаарын хөлгийн дэлгүүр (хоол хүнс, ундаа, тамхи зэрэг зүйлсийг оруулаад, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй);
    - (ii) шатах тослох материал, хэрэглээний техникийн хангамж;
    - (iii) хөдөлгүүр зэрэг сэлбэг хэрэгсэл; болон

d. Хэлэлцэн тохиролцогч нэг Талаас томилогдсон агаарын тээвэрлэгч дараахь нэг буюу хэд хэдэн асуудлыг шийдвэрлэхэд туслах зорилгоор Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтрүүлсэн компьютерийн тоног төхөөрөмж, эд ангиудыг:

- (i) агаарын хөлгийн засвар, үйлчилгээ, эсхүл үйлчилгээ үзүүлэх;
- (ii) нисэх онгоцны буудал эсхүл агаарын хөлөгт зорчигчдыг тээвэрлэх;
- (iii) ачааг агаарын хөлөгт ачих, буулгах;
- (iv) зорчигч, ачаанд аюулгүй байдлын шалгалт хийх;

(b)-(d) дэд зүйлд заасан зүйлс нь тухайн томилогдсон агаарын тээвэрлэгч олон улсын агаарын тээврийн үйлчилгээ бий болгох, засвар үйлчилгээ хийхтэй холбогдуулан агаарын хөлөгт эсхүл олон улсын нисэх буудлын хүрээнд ашиглах зориулалттай.

2. Гаалийн татвар, үндэсний онцгой албан татвар болон түүнтэй адилтгах үндэсний хураамжаас чөлөөлөх нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохиролцогч Талаас томилогдсон агаарын тээвэрлэгч болон тээвэрлэгчдэд үзүүлсэн үйлчилгээний зардалд үндэслэсэн хураамжид хамаарахгүй.
3. Энэ зүйлийн (1) дэх заалтад дурдсан тоног төхөөрөмж, хангамжийг холбогдох байгууллагын хяналт, хяналтан дор байлгахыг шаардаж болно.
4. Энэ зүйлд заасан чөлөөлөлтүүд Хэлэлцэн тохиролцогч нэг Талын томилогдсон агаарын тээвэрлэгч эсхүл тээвэрлэгчид нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт бусад агаарын тээвэрлэгч эсхүл тээвэрлэгчидтэй энэ зүйлийн (1) дэх заалтад заасан зүйлсүүдийг зээлүүлэх, шилжүүлэхээр хамтран ажиллах тохиолдолд мөн адил хэрэгжинэ.

## 11 ДҮГЭЭР ЗҮЙЛ

### Нисэхийн аюулгүй байдал

1. Олон улсын хуулиар хүлээсэн эрх үүргийнхээ дагуу, иргэний нисэхийн аюулгүй байдлыг хууль бус халдлагаас хамгаалахаар харилцан хүлээсэн үүрэг нь энэхүү Хэлэлцээрийн салшгүй бүрэлдэхүүн болно гэдгийг Хэлэлцэн тохиролцогч Талууд дахин нотолж байна. Хэлэлцэн тохиролцогч Талууд 1963 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Токио хотноо байгуулсан "Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон бусад тодорхой үйлдлийн тухай Конвенц", 1970 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Гааг хотноо байгуулсан "Агаарын хөлгийг хууль бусаар булаан авахтай тэмцэх тухай Конвенц", 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Монреаль хотноо байгуулсан "Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг таслан зогсоох тухай Конвенц", түүнд нэмэлт болгон 1988 оны 2 дугаар сарын 24-ний өдөр Монреаль хотноо байгуулсан "Олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүчирхийллийн хууль бус үйлдийг таслан зогсоох тухай Протокол", 1991 оны 3 дугаар сарын 1-нд Монреаль хотноо байгуулсан "Хуванцар тэсрэх бодисийг илрүүлэхийн тулд ялгах тэмдэглэгээ хийх тухай Конвенц" болон Хэлэлцэн

тохиролцогч Талууд гишүүнээр нэгдэн орсон нисэхийн аюулгүй байдлын тухай алив бусад конвенци, протоколын заалтуудад нийцүүлэн үйл ажиллагаа явуулна.

2. Хэлэлцэн тохиролцогч Талууд хүсэлт хүлээн авмагц, иргэний агаарын тээврийн хөлгийг хууль бусаар булааж авах, иргэний агаарын хөлөг болон түүний зорчигч, нисгэх баг, нисгэх буудал, агаарын навигацийн төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус үйлдэл, иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн аливаа бусад аюул заналаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бүхий л туслалцааг харилцан үзүүлнэ.
3. Иргэний агаарын хөлгийг хууль бусаар булаан авсан эсхүл булаан авах аюул занал учирсан, тухайн агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа, зорчигчид, нисгэх баг, агаарын хөлөг, нисгэх буудал эсхүл агаарын навигацийн төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн бусад хууль бус үйлдэл гарсан тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч Талууд дээрх үйлдэл эсхүл аюул заналыг шуурхай, аюулгүй байдлаар таслан зогсооход чиглэсэн холбоо барих болон бусад зүй зохистой арга хэмжээ авч харилцан туслаж ажиллана.
4. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр нутаг дэвсгэрт нь газардсан Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын агаарын хөлгийг хууль бус хөндлөнгийн үйлдэлд өрстөн гэж үзвэл хүний амь насыг хамгаалах нэн тэргүүний үүрэг хариуцлагын үүднээс тухайн агаарын хөлгийг нисгэх шаардлагатай болсноос бусад тохиолдолд түр саатуулах арга хэмжээ авна. Боломжтой тохиолдолд ийм арга хэмжээг харилцан зөвшилцсөний үндсэн дээр авна.
5. Хэлэлцэн тохиролцогч Хэлэлцэн тохиролцогч Талууд өөр хоорондын харилцаандаа Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас тогтоосон болон Чикагогийн Конвенцид Хавсралт болгон оруулсан, Хэлэлцэн тохиролцогч Талууд хэрэгжүүлэх боломжтой аюулгүй байдлын эдгээр заалтуудад нийцүүлэн үйл ажиллагаа явуулна. Хэлэлцэн тохиролцогч Талууд өөрийн нутаг дэвсгэрт нь байрладаг агаарын тээвэрлэгчид болон нисэх буудал ашиглагчдыг нисэхийн аюулгүй байдлын эдгээр заалтуудад нийцүүлэн үйл ажиллагаа явуулахыг шаардана. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр өөрийн үндэсний хууль тогтоомж, дүрэм журам, практик болон энэ зүйлд дурдсан нисэхийн аюулгүй байдлын стандартуудын хоорондын зөрүүтэй байдлын талаар Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа хүсэлтийн дагуу мэдэгдэнэ. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр эдгээр санал зөрөлдөөнийг хэлэлцэхийн тулд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талтай ямар ч үед хойшлуулалгүйгээр зөвлөлдөх хүсэлт гаргаж болно.
6. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр агаарын хөлөг ашиглагч өөрийн байгууллагаас Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэр рүү нэвтрэн орохдоо энэ зүйлийн (5) дахь заалтад заасан нисэхийн аюулгүй байдлын заалтыг дагаж мөрдөх шаардлагатайг зөвшөөрнө. Нисэн гарах, нутаг дэвсгэрт нь байх үед тухайн улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжинд нийцүүлсэн нисэхийн аюулгүй байдлын хууль, заалтыг дагах шаардлагатай. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр нутаг дэвсгэртээ агаарын хөлгийг хамгаалах, зорчигч, нисгэх баг, гар тээш, тээш, ачаа, агаарын хөлгийн нөөцийг агаарын хөлөгт зорчигчид авахаас өмнө, авах үед, эсхүл ачаа ачих үед шалгах зохих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Шаардлагатай тохиолдолд иргэний агаарын тээврийн аюулгүй байдалд заналхийлж буй аливаа аюулыг арилгахын тулд аюулгүй байдлын арга хэмжээг тохируулж болно. Хэлэлцэн

тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрээс гарах болон нутаг дэвсгэрт байх үед Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талаас шаардагдах аюулгүй байдлын заалтуудыг дагаж мөрдөх ёстой гэдгийг Хэлэлцэн тохиролцогч Тал бүр зөвшөөрнө.

7. Тодорхой нислэг (нислэгүүдэд)-т зориулан Аюулгүйн хамгаалалтын нэмэлт арга хэмжээ авах талаар аль нэг Тал хүсэлт гаргасан тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч аль ч Тал зохих зөвлөлдөөнийг хийх, хүсэлтийн шаардлагад нийцсэн арга хэмжээний хувилбарыг авч хэлэлцэх үүрэгтэй. Хэлэлцэн тохиролцогч аль ч Тал Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрээс үйлдэх тодорхой нислэг (нислэгүүдэд)-т холбогдуулан гаргасан хүсэлтэд дурдсан аюулгүйн хамгаалалтын нэмэлт арга хэмжээ нь хэрэгжүүлж болохуйц байх үүргийг хүлээнэ.
8. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр өөрийн бүрэн эрхт байдалд нийцүүлэн, ОУИНБ-аас хийсэн аудитын үр дүн болон тухайн Хэлэлцэн тохиролцогч Талаас авч хэрэгжүүлсэн засч залруулах арга хэмжээний талаарх мэдээллийг харилцан тохиролцсоны үндсэн дээр аюулгүй шилжүүлэх, тухайн мэдээллийг ашиглах, хадгалах, устгахад нээлттэй байлгана.
9. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын нисэхийн удирдах байгууллага Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт өөрийн нутаг дэвсгэр рүү чиглэсэн нислэгтэй холбогдуулан аюулгүй байдлын арга хэмжээний талаар үнэлгээ хийх боломжтой харилцан зохицуулалт хийх тухай Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талаас ирүүлсэн хүсэлтийг Хэлэлцэн тохиролцогч Тал бүр нааштай байдлаар авч үзнэ.
10. Хэлэлцэн тохиролцогч Талууд бие биеийнхээ бүрэн эрхт байдлыг харилцан хүндлэлийг хадгалан, Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал өөрийн нутаг дэвсгэрт нэвтрэхэд мөрдөх аюулгүйн хамгаалалтын арга хэмжээг баталж болно. Боломжтой тохиолдолд, Хэлэлцэн тохиролцогч тухайн Тал нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын мөрдөж буй аюулгүйн хамгаалалтын арга хэмжээнүүд болон илэрхийлж болох саналыг харгалзан үзнэ. Энэхүү Зүйл нь Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал аливаа нислэг эсхүл нислэгүүд түүний аюулгүйн хамгаалалтад аюул занал учруулахаар байна хэмээн үзсэн тохиолдолд өөрийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэхээс татгалзах эрхийг хязгаарлахгүй болохыг Хэлэлцэн тохиролцогч Тал тус бүр хүлээн зөвшөөрч байгаа болно.
11. Хэлэлцэн тохиролцогч Тал нь аюулгүй байдлын тодорхой заналхийллийг арилгахын тулд яаралтай арга хэмжээ авч болно. Ийм арга хэмжээг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талд нэн даруй мэдэгдэнэ.
12. Тээврийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд яаралтай арга хэмжээ авах шаардлага гарахыг оролцуулалгүйгээр, Хэлэлцэн тохиролцогч Талууд аюулгүй байдлын асуудлуудыг шийдвэрлэхдээ олон улсын агаарын тээврийн үйлчилгээнд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлж, хуулиар хязгаарлаагүй бол ямар арга хэмжээ авах шаардлагатай болон тохиромжтойг тодорхойлно.
13. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр энэхүү Хэлэлцээрээр зохицуулагдаж буй нислэгт нисэхийн аюулгүй байдлын ажилтнуудыг (IFSO) оролцуулан зэвсэгт бие бүрэлдэхүүнийг зорчихыг зөвшөөрөх тухай Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талаас ирүүлсэн хүсэлтийг нааштай байдлаар авч үзнэ. Хэлэлцэн тохиролцогч аль ч

Талаас IFSO-г илгээхийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талаас урьдчилан бичгээр зөвшөөрсөн тохиолдолд хийгдэнэ.

14. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын баталсан аюулгүй байдлын стандартын талаар хэдийд ч зөвлөлдөх хүсэлт гаргаж болно. Ийм зөвлөгөөн хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор зохион байгуулагдана. Хэлэлцэн тохиролцогч нэг Тал нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талаа энэ Зүйлд дурьдсан нисэхийн аюулгүй байдлын заалтуудыг хангахгүй байна гэж үзэх үндэслэл байна гэдэгт итгэлтэй байгаа бол Хэлэлцэн тохиролцогч энэ Тал зөвлөлдөөн яаралтай хийх хүсэлтээ Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талд тавьж болно. Ийм хүсэлт илгээснээс хойш 15 хоногийн дотор зөвшилцөлд хүрээгүй бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын агаарын тээвэрлэгчийн болон тээвэрлэгчдийн ашиглалтын зөвшөөрөл, техникийн зөвшөөрлийг хүчингүй болгох, түдгэлзэх, хязгаарлах үндэслэл болно.
15. Хэлэлцэн тохиролцогч Тал онцгой байдлын шаардлага гарвал 15 хоногийн хугацаа дуусахаас өмнө түр арга хэмжээ авч болно. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал энэ заалтын аюулгүй байдлын зүйл заалтыг дагаж мөрдсөн тохиолдолд, эсхүл Хэлэлцэн тохиролцогч хоёр Тал харилцан тохиролцвол энэ заалтад заасны дагуу авсан аливаа арга хэмжээг зогсооно.

## 12 ДУГААР ЗҮЙЛ

### Аюулгүй ажиллагаа

1. Аль ч Хэлэлцэн тохиролцогч Тал, нисгэх баг, агаарын хөлөг, эсхүл тэдгээрийн аливаа үйл ажиллагаанд хамааруулан Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал баталсан аюулгүй ажиллагааны стандартын асуудлаар зөвлөгөөн хийх хүсэлтээ хэдийд ч гаргаж болно. Ийм зөвлөгөөнийг хүсэлт гаргасан өдрөөс хойш гуч 30 хоногийн дотор хийнэ.
2. Ийм зөвлөгөөний дүнд Хэлэлцэн тохиролцогч нэг Тал, Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал нь дээрх салбаруудад аюулгүй ажиллагааны стандартыг наанадаж тухайн үед Чикагогийн Конвенцын дагуу тогтоосон хамгийн доод стандарттай тэнцүү тогтоон идэвхтэй мөрдөхгүй, зохион байгуулахгүй байгааг тогтоовол Хэлэлцэн тохиролцогч эхний Тал Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа эдгээр дутагдлууд, наад захын стандартыг хангахад шаардлагатай гэж үзсэн алхмуудын талаар мэдэгдэх бөгөөд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал дутагдлаа засах зохих арга хэмжээ авна. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал холбогдох хугацаанд буюу ямар ч тохиолдолд арван тав (15) эсхүл өөрөөр тохирсон хугацаанд зохих арга хэмжээг аваагүй нь энэхүү Хэлэлцээрийн 5 дугаар зүйл (Үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг цуцлах эсхүл түдгэлзүүлэх)-ийн 1(h) заалтыг хэрэглэх үндэслэл болно.
3. Чикагогийн Конвенцын 16, 33 дугаар зүйлд заасан үүргийг үл харгалзан Хэлэлцэн тохиролцогч нэг Тал өөрөө эсхүл агаарын тээвэрлэгчийн нэрийн өмнөөс түрээсийн гэрээгээр, Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэр рүү эсхүл нутаг дэвсгэрээс явуулж буй үйлчилгээндээ ашиглаж байгаа аливаа агаарын хөлөг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байх үед нөгөө Хэлэлцэн тохиролцогч энэ Талын эрх бүхий төлөөлөгчид агаарын хөлөг бүхээгт, агаарын хөлгийн эргэн тойронд, агаарын хөлгийн болон нисгэх багийн бичиг баримт аль аль

нь хүчинтэй эсэх, агаарын хөлгийн тухайн үеийн гадаад байдал, түүний тоног төхөөрөмжийг (энэ зүйлд "газар дээрх шалгалт" гэж нэрлэх.) үзэж шалгаж болно гэж тохиролцсон бөгөөд үзлэг шалгалт нислэгийг саатуулах үндэслэл болохгүй байвал зохино.

4. Газар дээрх нэг эсхүл хэд хэдэн удаагийн ийм хяналт шалгалтын үр дүнд:

(а) Агаарын хөлөг эсхүл түүний үйл ажиллагаа нь тухайн үед Чикагогийн Конвенцын дагуу тогтоосон наад захын стандартад нийцэхгүй байна гэж үзэх ноцтой үндэслэл илэрвэл; эсхүл

(б) Тухайн үед Чикагогийн Конвенцын дагуу тогтоосон аюулгүй ажиллагааны стандартыг идэвхтэй мөрдөхгүй, зохион байгуулахгүй байна гэж үзэх ноцтой үндэслэл илэрвэл,

хяналт шалгалт явуулсан Хэлэлцэн тохиролцогч Тал, Чикагогийн Конвенцын 33 дугаар зүйлийн зорилгод нийцүүлэн тухайн агаарын хөлөг түүнчлэн тухайн агаарын хөлгийн нисэх багт гэрчилгээ, үнэмлэх олгоход, эдгээрийг хүчин төгөлдөр гэж үзэхэд тавигдсан шаардлага эсхүл тухайн агаарын хөлгийг ашиглахад тавигдсан шаардлага нь Чикагогийн Конвенцын дагуу тогтоосон доод захын стандартыг хангаагүй эсхүл стандартаас илүүгүй байна гэсэн дүгнэлтээ чөлөөтэй гаргах эрхтэй.

5. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын агаарын тээвэрлэгчийн ашиглаж буй агаарын хөлөгт энэ зүйлийн (3) дахь заалтын дагуу газар дээрх шалгалт хийх зорилгоор нэвтрүүлэхийг тухайн агаарын тээвэрлэгч татгалзсан тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал энэ зүйлийн (4) дэх заалтад дурдсан ноцтой үндэслэл үүссэн гэж үзэж, дээрх заалтад дурдсан дүгнэлт гаргах эрхтэй.

6. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр нэг эсхүл хэд хэдэн удаагийн газар дээрх шалгалтын үр дүн, газар дээрх шалгалт хийлгэхээр нэвтрүүлэхийг зөвшөөрөөгүй, зөвлөлдөөн эсхүл бусад төрлийн харилцаа холбооны дүнд аюулгүй ажиллагааг хангахад чиглэсэн арга хэмжээг нэн даруй авах зайлшгүй шаардлага үүсгэсэн гэж дүгнэвэл Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын агаарын тээвэрлэгчид олгосон үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх эсхүл өөрчлөх эрхээ хадгалж үлдэнэ.

7. Хэлэлцэн тохиролцогч нэг Талаас энэ зүйлийн (2) эсхүл (6) дугаар заалтын дагуу авч хэрэгжүүлсэн аливаа арга хэмжээ нь тухайн арга хэмжээг авах болсон үндэслэл арилснаар дуусгавар болно.

### 13 ДУГААР ЗҮЙЛ

#### Аяллын дугаар хамтран ашиглах

Томилогдсон агаарын тээвэрлэгч эсхүл тээвэрлэгчид холбогдох хууль тогтоомж болон өрсөлдөөний зохицуулалтын дагуу аливаа агаарын тээвэрлэгч эсхүл тээвэрлэгчидтэй аяллын дугаар хамтран ашиглах зохицуулалтад орж болно.

а) зохицуулалт хамаарах тухайн үйлчилгээний нэгэн хэсгийн нислэг гүйцэтгэгч агаарын тээвэрлэгч нь тухайн нислэг гүйцэтгэх эрхтэй байх;

- b) борлуулсан тасалбар бүрийн хувьд худалдан авагч худалдан авах үедээ үйлчилгээний холбогдох хэсэг тус бүрт ямар агаарын тээвэрлэгч үйлчилгээг үзүүлж буй тухай мэдээлэлтэй байна.

#### **14 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

##### **Түрээс**

1. Хэлэлцэн тохиролцогч Тал бүрээс томилогдсон агаарын тээвэрлэгчид Хэлэлцэн тохиролцогч Талуудын иргэний нисэхийн удирдах байгууллагуудаас агаарын хөлөг (агаарын хөлөг болон нисгэх баг) ашиглах зөвшөөрөл авсаны үндсэн дээр бусад агаарын тээвэрлэгчид болон аливаа компаниас түрээсэлсэн агаарын хөлгөөр тогтоосон шугамаар тохиролцсон үйлчилгээ үзүүлж болно.
2. Энэхүү зүйлийн (1) дэх заалтын дагуу түрээсийн нөхцлөөр агаарын хөлөг ашиглахдаа томилогдсон агаарын тээвэрлэгчид Хэлэлцэн тохиролцогч Талуудаас олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаанд тавигддаг холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын нөхцөлийг хангана.

#### **15 ДУГААР ЗҮЙЛ**

##### **Газрын үйлчилгээ**

Хэлэлцэн тохиролцогч холбогдох Талын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр хууль тогтоомжийн дагуу агаарын тээвэрлэгч Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт өөрийн газрын үйлчилгээ (өөртөө үйлчлэх) эрхлэх эсхүл үзэмжээрээ үйлчилгээний өрсөлдөгч байгууллагууд дотроос сонгон газрын үйлчилгээг бүхэлд нь эсхүл зарим үйлчилгээг хэрэгжүүлэх эрхтэй. Хууль тогтоомжууд өөртөө үйлчлэхийг хязгаарласан эсхүл хориглосон, газрын үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хооронд үр нөлөөтэй өрсөлдөөн байдаггүй тийм газарт томилогдсон агаарын тээвэрлэгч үйлчилгээний байгууллага эсхүл байгууллагуудад алагчлалгүй хандах үндсэн дээр өөртөө үйлчлэх болон газрын үйлчилгээнд оролцох боломж олгохоор гэрээ байгуулна.

#### **16 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

##### **Орлого гуйвуулах**

Хэлэлцэн тохиролцогч Тал бүрийн томилогдсон агаарын тээвэрлэгчдэд агаарын тээврийн үйлчилгээ болон агаарын тээвэртэй шууд холбоотой үйл ажиллагааны борлуулалтаас олсон орон нутгийн бүх орлогыг өөрийн сонгосон улсдаа орон нутгийн хэмжээнд төлж байгаа мөнгөнөөс давсан дүнгээр шилжүүлэхийг зөвшөөрнө. Валютыг шуурхай хөрвүүлэх, мөнгөн гуйвуулга нь тухайн орлогыг хөрвүүлэлт, гуйвуулгад өгөх үед мөрдөгдөж байсан захзээлийн ханшаар, хязгаарлалтгүйгээр зөвшөөрөгдөх бөгөөд ийм хөрвүүлэлт, мөнгөн гуйвуулга хийхэд банкны авдаг ердийн хураамжаас бусад хураамж төлөхгүй.



## 17 ДУГААР ЗҮЙЛ

### Агаарын тээвэрлэгчийг төлөөлөх, үйлчилгээ худалдаа

Томилогдсон агаарын тээвэрлэгч нь:

- (a) Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтрэх, оршин суух, хөдөлмөр эрхлэхтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журмын дагуу агаарын тээвэрлэгч нь олон улсын агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай гэж үзсэн өөрийн удирдах, техникийн болон бусад мэргэжлийн ажилтнуудыг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ажиллуулж болно.
- (b) Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бусад байгууллага, компани, агаарын тээвэрлэгчдийн боловсон хүчин болон үйлчилгээг ашиглаж болно.
- (c) Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт төлөөлөгчийн газар байгуулах; болон
- (d) Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт олон улсын агаарын тээврийн үйлчилгээ болон дагалдах үйлчилгээний борлуулалт, маркетингийг шууд эсхүл тухайн агаарын тээврийн компаниас томилогдсон төлөөлөгч болон бусад зуучлагчаар дамжуулан хийж болно. Агаарын тээвэрлэгч нь тухайн тээврийн болон дагалдах үйлчилгээг тухайн улсын мөнгөн тэмдэгтээр эсхүл чөлөөтэй хөрвөх бусад валютаар худалдах бөгөөд хэн ч чөлөөтэй худалдан авах боломжтой.

## 18 ДУГААР ЗҮЙЛ

### Ашиглагчдад ногдуулах хураамж

1. Тал бүр төлбөр ногдуулах эрх бүхий байгууллагууд, хуулийн этгээд нөгөө Талаас томилогдсон агаарын тээвэрлэгчдэд ногдуулж болох ашиглалтын хураамж нь шударга, үндэслэлтэй, алагчлаагүй, бусад төрлийн хэрэглэгч нарт тэгш хувааж тооцсон байна. Нөгөө Талаас томилогдсон агаарын тээвэрлэгчдэд ногдуулах ашиглалтын ийм хураамж нь хураамж ногдуулах үед өөр бусад агаарын тээврийн компанид ногдуулах хураамжаас дутуугүй тохиромжтой нөхцөлөөр үнэлэн ногдуулсан байна.
2. Хураамж, ногдуулах эрх бүхий байгууллагаас нөгөө Талын агаарын тээвэрлэгчдэд эрх бүхий байгууллагууд, хуулийн этгээдийн ногдуулсан ашиглалтын хураамж нь тухайлсан нисэх буудал, түүний хүрээлэн буй орчин, агаарын навигаци, нисэхийн аюулгүй байдлын төхөөрөмжүүд болон нисэх буудлын системийн хүрээнд нисэх буудал дээр үзүүлсэн гэхдээ хэтрүүлээгүй үйлчилгээний зардлыг бүрэн хэмжээгээр тусгасан байх ба гэхдээ үүнээс хэтрүүлэхгүй тооцсон байна. Энэхүү хураамжид эд хөрөнгийн үнэлгээнээс эргэн төвлөрөх орлогын зүй зохист өгөөж багтаж болно. Ашиглалтын хураамж ногдуулж буй төхөөрөмж, үйлчилгээ нь үр дүнтэй, эдийн засгийн тооцоон дээр үндэслэсэн байна.
3. Тал бүр нутаг дэвсгэртээ хураамж ногдуулах эрх бүхий байгууллагууд, хуулийн этгээд, тоног төхөөрөмж ашиглаж үйлчлүүлж буй агаарын томилгодсон агаарын тээвэрлэгчид хооронд зөвлөлдөх уулзалт хийхийг дэмжинэ. Тал бүр хураамж ногдуулах эрх бүхий байгууллагууд, хуулийн этгээд, томилогдсон агаарын тээвэрлэгчид энэ Зүйлийн (1), (2) дахь заалтад тодорхойлсон зарчмын дагуу хураамж үндэслэлтэй эсэх талаар нарийн нягт, ил тод мэдээлэл авахад шаардлагатай байж болох тийм мэдээлэл солилцохыг дэмжинэ.

Тал тус бүр ашиглалтын хураамж ногдуулах эрх бүхий байгууллагуудыг ашиглалтын хураамжид аливаа өөрчлөлт оруулахаасаа өмнө, ашиглагчдад саналаа илэрхийлэх боломж олгох үүднээс өөрчлөлт оруулах тухай үндэслэлтэй мэдэгдлийг урьдчилан өгөхийг дэмжинэ.

4. Энэ Зүйлийн заалтуудын дор дурдсан нөхцлөөс бусад тохиолдолд 22 дугаар Зүйл (Маргаан шийдвэрлэх)-ийн дагуу маргаан шийдвэрлэх явцад аль ч Талыг энэ Зүйлийн заалтыг зөрчсөнд тооцохгүй. Үүнд:

(а) нөгөө Талын гомдлын үндэслэл болсон хураамж эсхүл хураамж ногдуулж буй ажиллагааг зохих хугацаанд нягталж үзээгүй бол;

(б) нягтлан шалгасны дараа энэ Зүйлийн заалтад нийцээгүй аливаа хураамж эсхүл хураамж ногдуулж буй ажиллагааг өөрийн хүч боломжийн хирээр засах бүхий л алхмыг хийгээгүй бол.

## 19 ДҮГЭЭР ЗҮЙЛ

### Олон төрөлт тээвэр

Хэлэлцэн тохиролцогч Тал бүрийн агаарын тээвэрлэгчид Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын эсхүл гуравдагч улсын нутаг дэвсгэрт байрлах аль ч цэгээс болон цэг рүү олон улсын агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор олон төрөлт тээврийн үйлчилгээг үзүүлж болно. Агаарын тээвэрлэгч нь олон төрөлт тээврийг өөрсдөө хийх эсхүл бусад агаарын тээвэрлэгчтэй байгуулсан аяллын дугаар хуваан ашиглах зэрэг зохицуулалтаар хийлгэхээ сонгож болно. Зорчигч, тээвэрлэгчдэд холбогдох тээврийн үйлчилгээ үзүүлэгчийн талаар мэдээлсэн тохиолдолд тус олон төрөлт тээвэр нь агаарын болон олон төрөлт тээврийг хослуулсан нэг үнэтэй дамжин өнгөрөх үйлчилгээ байж болно.

## 20 ДУГААР ЗҮЙЛ

### Хүрээлэн буй орчны хамгаалал

(1) Хэлэлцэн тохиролцогч Талууд нь нисэхийн тогтвортой хөгжлийг дэмжих замаар хүрээлэн буй орчныг хамгаалах хэрэгцээг дэмжинэ.

(2) Хүрээлэн буй орчныг хамгаалах арга хэмжээг тогтоохдоо үл тохирол гарсанаас бусад тохиолдолд ОУИНБ-аас Чикагогийн Конвенцын хавсралтад заасан агаарын тээврийн байгаль орчны стандартыг баримтална.

(3) Энэхүү Хэлэлцээрт заасан ямар ч зүйл нь Хэлэлцэн тохиролцогч Талуудын агаарын тээврийн хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, эсхүл түүнийг арилгахын тулд зохих бүх арга хэмжээг авах эрх бүхий байгууллагын эрхийг хязгаарласан гэж тайлбарлахгүй бөгөөд хууль болон иргэний харьяаллаар ялгахгүйгээр үйлчилнэ.

## 21 ДҮГЭЭР ЗҮЙЛ

### Зөвлөлдөөн

Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль нэг нь энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх, тайлбарлах, хэрэглэх эсхүл өөрчлөх эсхүл дагаж мөрдөх талаар зөвлөлдөх хүсэлтийг хэдийд ч гаргаж болно. Хэлэлцэн тохиролцогч Талууд өөрөөр тохиролцоогүй бол Нисэхийн эрх бүхий байгууллага хоорондын ийм зөвлөлдөх уулзалт нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал бичгээр хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор эхэлнэ.

## 22 ДУГААР ЗҮЙЛ

### Маргаан шийдвэрлэх

1. Хэлэлцэн тохиролцогч Талуудын хооронд энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, мөрдөхтэй холбоотой аливаа маргаан үүсвэл Хэлэлцэн тохиролцогч Талууд юуны түрүүнд хэлэлцээ хийх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
2. Хэлэлцэн тохиролцогч Талууд маргааныг хэлэлцэн шийдвэрлэж чадахгүй бол Хэлэлцэн тохиролцогч Талууд харилцан зөвшөөрсөн тийм хүн эсхүл байгууллагад хандаж болох бөгөөд эсхүл Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын хүсэлтээр уг маргааныг шийдүүлэхээр дараах байдлаар бүрдүүлсэн гурван арбитрчаас бүрдсэн шүүхэд хандана:
  - (a) Хэлэлцэн тохиролцогч Тал бүр арбитрын хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор нэг арбитрчийг томилно. Шүүхийн даргын үүргийг гүйцэтгэх гуравдагч улсын иргэнийг хоёр дахь арбитрч томилогдсоноос хойш 60 хоногийн дотор хоёр арбитрчийн тохиролцоогоор гурав дахь арбитрчаар томилно;
  - (b) хэрэв дээр дурдсан хугацаанд ямар нэгэн томилгоо хийгдээгүй бол Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль нэг нь шаардлагатай томилгоог 30 хоногийн дотор хийхээр Олон улсын шүүхийн Ерөнхийлөгчид хүсэлт гаргаж болно. Хэрэв Ерөнхийлөгч Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль нэгнийх нь иргэншилтэй бол Дэд Ерөнхийлөгчөөс томилох хүсэлт гаргана. Дэд Ерөнхийлөгч нь Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль нэгнийх нь иргэншилтэй бол Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль нэгнийх нь харьяалалгүй олон улсын шүүхийн дараагийн ахлах албан тушаал хаших гишүүнээр томилох хүсэлтийг гаргана.
3. Цаашид энэ зүйлд зааснаас бусад буюу Хэлэлцэн тохиролцогч Талуудын тохиролцооноос бусад тохиолдолд шүүх харьяаллынхаа хязгаарыг тодорхойлж, өөрийн журмыг тогтооно. Шүүхийн заавар, эсхүл Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль нэгнийх нь хүсэлтээр арбитрын шүүх бүрэлдэхүүн бүрэн бүрдүүлснээс хойш 30-аас доошгүй хоногийн дотор арбитрын шүүх хуралдаанд оролцох тодорхой асуудал, баримтлах тодорхой журмыг тодорхойлох бага хурлыг зохион байгуулна.
4. Хэлэлцэн тохиролцогч Талууд өөрөөр тохиролцоогүй буюу шүүхээр тогтоогоогүй тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч Тал бүр шүүх бүрэлдэхүүн бүрэн байгуулагдсанаас хойш 45 хоногийн дотор санамж бичиг ирүүлнэ. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын санамж бичгийг ирүүлснээс хойш 60 хоногийн дотор хариу илгээж болно. Шүүх хариу авах ёстой

байсан өдрөөс 30 хоногийн дотор Хэлэлцэн тохиролцогч Талуудын хүсэлтээр эсхүл өөрийн үзэмжээр шүүхийн сонсгол явуулна.

5. Шүүхийн сонсгол дууссанаас хойш 30 хоногийн дотор, хэрэв шүүхийн сонсгол хийгдээгүй бол аль аль хариуг илгээсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор бичгээр шийдвэр гаргахыг оролдоно. Шийдвэрийг олонхийн саналаар гаргана.
6. Хэлэлцэн тохиролцогч Талууд шийдвэрийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор түүнийг тодруулах хүсэлт гаргаж болох бөгөөд уг тайлбарыг хүсэлт гаргаснаас хойш 15 хоногийн дотор гаргана.
7. Шүүхийн шийдвэр нь эцсийн байх бөгөөд Хэлэлцэн тохиролцогч Талууд заавал биелүүлэх үүрэгтэй.
8. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр өөрийн томилогдсон арбитражийн зардлыг хариуцна. Шүүхийн бусад зардлыг Хэлэлцэн тохиролцогч Талууд энэ зүйлийн (2)(b)-д заасан зарчмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Олон улсын шүүхийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, гишүүнээс гаргасан аливаа зардлыг оролцуулан тэнцүү хуваана.

## 23 ДУГААР ЗҮЙЛ

### Нэмэлт, өөрчлөлт

1) Хэлэлцэн тохиролцогч аль ч Тал 21 дүгээр зүйлд (Зөвлөлдөөн) заасны дагуу энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах талаар зөвлөлдөх хүсэлт гаргаж болно.

(2) Энэхүү Хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь түүнийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын хууль тогтоомжийн шаардлагаа хангасан талаар Хэлэлцэн тохиролцогч талууд харилцан мэдэгдсэн сүүлчийн дипломат нот бичиг хүлээн авсан өдрөөс хүчин төгөлдөр болно. Хэлэлцэн тохиролцогч Талуудын тохиролцоогоор ийм нэмэлт, өөрчлөлтийг түр хугацаагаар хэрэглэж болно.

(3) Хэлэлцэн тохиролцогч Талуудын хүлээн зөвшөөрсөн олон талт агаарын тээврийн ерөнхий конвенц хүчин төгөлдөр болсон тохиолдолд уг конвенцын заалтыг дагаж мөрдөнө. Энэхүү Хэлэлцээрийг олон талт Конвенцын заалттай холбогдуулан дуусгавар болгох, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, өөрчлөх, нэмэлт оруулах асуудлыг тодорхойлох зорилгоор аливаа хэлэлцүүлгийг энэхүү Хэлэлцээрийн 21 дүгээр зүйлд (Зөвлөлдөөн) заасны дагуу явуулна.

## 24 ДУГААР ЗҮЙЛ

### Олон улсын иргэний нисэхийн байгууллагад бүртгүүлэх

Энэхүү Хэлэлцээр, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ОУИНБ)-д бүртгүүлэхээр мэдэгдэнэ.

## 25 ДУГААР ЗҮЙЛ

### Хэлэлцээрийг цуцлах

1. Хэлэлцэн тохиролцогч аль ч Тал энэхүү Хэлэлцээрийг цуцлах тухай мэдэгдлээ Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа бичгээр хэдийд ч өгч болно. Ийм мэдэгдлийг ОУИНБ-д нэгэн зэрэг мэдэгдэнэ.
2. Хэлэлцэн тохиролцогч Тал Хэлэлцээр цуцлах хугацаа дуусгавар болохоос өмнө харилцан хэлэлцсэний дагуу мэдэгдлээ эргүүлэн татсанаас бусад тохиолдолд энэхүү Хэлэлцээрийг цуцлах тухай бичгээр мэдэгдэл авсан өдрөөс хойш нэг жилийн хугацаа дуусгавар болохын өмнөх өдрийн шөнө дунд (мэдэгдэл хүлээн авсан тухайн газар) энэхүү Хэлэлцээр цуцлагдана.

## 26 ДУГААР ЗҮЙЛ

### Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү хэлэлцээр нь түүнийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын хууль тогтоомжийн шаардлагаа хангасан талаар Хэлэлцэн тохиролцогч талууд дипломат ноот бичгээр харилцан мэдэгдсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
2. 2000 оны 3 дугаар сарын 1-ний өдөр Лондон хотноо байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Засгийн газар хооронд байгуулсан Агаарын харилцааны тухай хэлэлцээр нь энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дуусгавар болно.


Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохыг гэрчилж, тус тусын засгийн газраас зохих ёсоор эрх олгогдсон эрх бүхий этгээдүүд энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурж, баталгаажуулав.

Энэхүү Хэлэлцээрийг *Улаанбаатар* хотноо *2024* оны *01* сарын *23* өдөр монгол, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэр тус бүр адил хүчинтэй байна. Хэлэлцээрийг тайлбарлахад ямар нэгэн зөрүү гарвал англи хэлээрх эхийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН  
НЭГДСЭН ХААНТ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



## ХАВСРАЛТ

### МАРШРУТЫН ХУВААРЬ

#### I Хэсэг

Монгол Улсын томилсон агаарын тээвэрлэгч эсхүл агаарын тээвэрлэгчдийн ашиглах маршрутууд:

Монгол Улс дахь цэг - Завсрын цэгүүд – Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс дахь цэгүүд – Хилийн чанад дахь цэгүүд

#### ТЭМДЭГЛЭЛ:

1. Монгол Улсаас эхлэлтэй эсхүл Монгол Улсад төгсөж байгаа нислэгийн үйлчилгээнд Завсрын эсхүл чанад дахь цэгүүдийг алагсаж болно.
